




**ЭРДЭНЭТ БУЛГАНЫ  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТЕХНИКИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС**

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баяцагаан баг  
Утас: +976 75957008, Факс: +976 70352623  
Вэб: [www.edc.mn](http://www.edc.mn) Цахим шуудан: [info@edc.mn](mailto:info@edc.mn)



2023 оны 02 сарын 28

**ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 22 / 23**

**Нэг ерөнхий мэдээлэл:**

- 1.1 Хүсэлтийн дугаар: 01/34
- 1.2 Хэрэглэгчийн нэр, регистр: ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА РД-6866425
- 1.3 Хэрэглэгчийн байршил: УБ, СБДүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд, С.Амарын гудамж, Лагшан төв
- 1.4 Техникийн нөхцөл авах объектын байршил, Өгий нуурын урд эрэгт баруун хадан хясаанд хаягийн тодорхойлт: байрлалтай 0.75 га тайлбай бүхий газар
- 1.5 Ажил үйлчилгээний зориулалт: Усан замын тээврийн "Хяналтын пост"
- 1.6 Техникийн нөхцөл олгох үндэслэл:
  1. Монгол улсын далайн захиргаа төрийн байгууллага, албан газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2018 оны 04 сарын 13-ны өдрийн 000156362 тоот гэрчилгээ.
  2. Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 2023 оны 01 сарын 26-ны өдрийн А/08 тоот захирамжийг үндэслэсэн 0000160415 тоот гэрчилгээ.
  3. Архангай аймаг, Өгийнуур сум засаг даргын 2023 оны 01 сарын 26-ны өдрийн А/08 тоот

газар эзэмшүүлэх тухай захирамж.

4. Архангай аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын газар эзэмших эрхийн байршлын кадастрын зураг.

5. Техникийн нөхцөл хүссэн албан бичиг.

6. 2023 оны 02 сарын 28-ны өдрийн компанийн төв комиссын хурлын шийдвэрээр.

1.7 Техникийн нөхцөлийн Шинэ холболт ангилал:

1.8 Тооцооны бүрэн чадал: 40 кВА /Дөч/  
(тоогоор) (үсгээр)

#### **Хоёр. Холболтын цэг:**

2.1 35/10 кВ-ын Өгийнуур дэд станц, ячейк №2 10 кВ-ын ТХГ ЦДАШ-ын тулгуур №236-г салбарлалтын анкер болгон салбар шугамын эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан бүрээстэй агаарын шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх.

#### **Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:**

- 3.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг- Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орсон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажсан байх.
- 3.2 Дэд өртөөний 0.4 кВ талын ерөнхий оруулгуудад ЭБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг дэмждэг, 4G модемтой, тасалж залгах команд өгөх боломжтой, 3 фазын ухаалаг тоолуур, ачаалалд тохирсон гүйдлийн трансформатор болон тоолуураас өгөгдөл цуглуулж дамжуулах зориулалттай, 4G модемтой концентратыг тусгай хайрцагт суурилуулах.
- 3.3 Ажлын зураг төслийг зөвшилцөх шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг ЭБЦТС ТӨХК-аар хянуулсан байх.

#### **Дөрөв. Тусгай заалтууд:**

- 4.1 Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 63 кВА чадалтай, 10/0.4 кВ-ын хүчдэлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий дэд өртөөг /КТП/ өөрийн эзэмшлийн газарт шинээр барих.
- 4.2 Шинээр баригдах дэд өртөөний 0.4 кВ талын ХБ 4-өөс доошгүй гаргалгаатай байх.
- 4.3 Дэд өртөө нь хашаатай байх ба аюулгүй ажиллагааны плакат суурилуулсан байх.

- 4.4** Буусан тоног төхөөрөмжийг Монгол улсын засгийн газрын 2020 оны 97-р тогтоолын 2.7.2-т заасны дагуу ЭБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
- 4.5** Шугам, дэд өртөөний гүйцэтгэлийн зургийг autocad-ын файл хэлбэрээр гаргаж, ашиглагч байгууллага ЭБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа шугамын холболтын муфтуудыг заасан мөн бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.
- 4.6** Дэд өртөөний бүх тоноглол, гаргалгаа кабель шугамд НСД, ААД, ТАД-д заагдсаны дагуу хаягжилт, плакатжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.
- 4.7** Барилга угсралтын ажлын зураг нь ЦБД, ТАД, ААД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, ЭХ хэрэглэх дүрэм болон ЭБЦТС ТӨХК-аас хэрэгжүүлж байгаа ашиглалт борлуулалтын арга хэмжээний шаардлагуудыг хангасан байна.
- 4.8** Цахилгаан хангамжийн III зэрэглэлийн шугамаас холбогдож байгаа тул цахилгаан хүч тасарсан үед тэжээх нөөц эх үүсгүүр /дизель генератор/ суурилуулах.
- 4.9** Дэд станц, тоноглол нь хоёр талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан мөн аваарын нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель генератор/-тэй бол харьяа түгээх төвтэй Шуурхай ажиллагааны гэрээ байгуулах.
- 4.10** Түгээх сүлжээний үндсэн шугам нь хэт урт, ачаалал ихтэйгээс шалтгаалан хэрэглэгчид очих эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүчдэл өргөх төхөөрөмж суурилуулах болон техникийн нэмэлт арга хэмжээнүүдийг ЭБЦТС ТӨХК-тай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Нэмэлт ажилтай холбоотой гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.
- 4.11** ЭБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
- 4.12** Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу  $\pm 10\%$ - ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.
- 4.13** Өөрийн дэд станц, шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.
- 4.14** Цахилгаан дамжуулах агаарын шугам нь:
- 4.14.1. ЦДАШ-ын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төсөл боловсруулах шатанд

хангагч байгууллага болон бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцөн сонгох,

4.14.2. ЦДАШ-ын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр болон төмөр бетон байх,

4.14.3. Дамжуулагчийн хөндлөн огтлолыг ачаалалтай уялдуулан, тооцоогоор сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох,

4.14.4. Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухайн газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох.

**4.15 Цахилгаан дамжуулах кабель шугам нь:**

4.15.1) Шинээр татах 10 кВ- ын кабель шугам нь MNS 6819:2015 стандартын шаардлагыг хангасан байна.

4.15.2) Шинээр татах 10 кВ- ын кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор сонгох, ашиглагч ЭБЦТС ТӨХК-тай зөвшилцөх.

4.15.3) Шинээр татах кабель шугам 10 кВ- ын хүчдэлийн түвшинд ажиллах, гадна орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх.

**Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:**

- 5.1 Шугам, дэд өртөөний "Ажлын зураг төсөл"- ийг ЦБД, ТАД, ААД, ГАБХД, ЭХ- ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Эрчим хүч хэрэглэх дүрмийн дагуу хийж гүйцэтгэх бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
- 5.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
- 5.3 Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
- 5.4 "Эрчим хүчний тухай хууль"- ийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.
- 5.5 "Эрчим хүчний тухай хууль"- ийн 30.1.8- д "Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах" гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторх цахилгаан тоног төхөөрөмждөө

байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээ хийлгэх.

- 5.6 Түгээх сүлжээнд залгагдах болон залгаатай байгаа хувийн шугам тоноглол эзэмшигч нь өөрийн шугамын урт, тоноглолын хүчин чадлаас хамааруулан тус компанийн харьяа түгээх төвтэй шуурхай ажиллагааны гэрээг байгуулах.
- 5.7 Хэрэглэгч нь техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлаа бүрэн ашиглаж чадаагүй нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр нотлогдсон бол олгогдсон чадлын хэмжээг бууруулж дахин техникийн нөхцөл олгоно.
- 5.8 “Эрчим хүчний тухай хууль”- ийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 5.9 Өөрийн шугам сүлжээнээс ЭБЦТС ТӨХК- ийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.
- 5.10 Дэд өртөө, щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн фото зургаар баримтжуулж холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
- 5.11 Цахилгаан эрчим хүчний тооцоог ЭБЦТС ТӨХК- ийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

#### **Зургаа. Бусад:**

- 6.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”- ийн 2.17- д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.  
2.17. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.  
Үүнд:  
2.17.1. хүчинтэй хугацаа дууссан,  
2.17.2. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн,  
2.17.3. холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн,  
2.17.4. дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн.
- 6.2 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”- ийн 2.9- д заасны дагуу 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

- 6.3 Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”- ийн 2.13, 2.16- д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.

**Техникийн комиссын гишүүд**

ТБХ-ийн дарга

БХ-ийн дарга

Ашиглалтын инженер

Шинэ холболтын инженер



Г. Золбоо

Д.Мөнхсүлд

Б.Ариунбаяр

Ч.Лхагвасүрэн

Г.Золбоо